



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/899

Эрдэнэт

┌ Үндсэн хөрөнгө бүртгэлд авах тухай ┐

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 /г/, 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар дугаар зүйлийн 78.2.1, 78.2.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 49 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Геологи хайгуулын анги 2016 онд Баян-Өндөр уулын байгалийн нөхөн сэргээлтийн зориулалтаар гаргасан, 10.425.000 төгрөгийн үнэ бүхий “Баян-Өндөр уулын амны худаг”-ийг Эрдэнэт үйлдвэрийн Геологи хайгуулын ангийн албан бичиг, гүйцэтгэлийн баримтыг үндэслэн Байгаль орчин аялал жуулчлалын газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, Орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар /н.Оюунгэрэл/-т, байгууллагынхаа хөрөнгө санхүүгийн бүртгэлд зохих журмын дагуу бүртгэх, хөрөнгийн цаашдын ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга, нягтлан бодогч нарт даалгасугай.



Д.БАТЛУТ